



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 09 сарын 03 өдөр

Дугаар 1040

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйл, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9.1.2, Төсвийн тухай хуулийн 16.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Монгол Улсын иргэний гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түр түдгэлзүүлэх болон иргэний баримт бичигт бүртгэл хөтлөхөд хориг тавих, цуцлах бүртгэл хөтлөх журам"-ыг 1 дүгээр, "Түдгэлзүүлсэн болон хориг тавьсан, цуцалсан бүртгэлийн дэвтэр"-ийн загварыг 2 дугаар, "Улсын байцаагчийн хориг тавих шийдвэр"-ийн маягтын загварыг 3 дугаар, "Улсын байцаагчийн хориг цуцлах шийдвэр"-ийн маягтын загварыг 4 дүгээр хавсралтын ёсоор тус тус баталсугай.


2. "Монгол Улсын иргэний гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түр түдгэлзүүлэх болон иргэний баримт бичигт бүртгэл хөтлөхөд хориг тавих, цуцлах бүртгэл хөтлөх журам"-ыг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг нийт бүртгэлийн хяналтын улсын /ахлах/ байцаагч нарт үүрэг болгосугай.

3. Түдгэлзүүлсэн болон хориг тавьсан, цуцалсан бүртгэлийн дэвтэр, Улсын байцаагчийн хориг тавих, цуцлах, шийдвэрийн маягтыг хэвлүүлэхтэй холбогдсон схнхүүжилтийг холбогдох зардлаас гаргахыг тус газрын Тамгын газрын Санхүү, бүртгэлийн хэлтсийн дарга Б.Өэлүн-Үжинд зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг тус газрын дэд дарга Р.Даваадорж, Бүртгэлийн хяналтын газрын дарга Ц.Ганзориг нарт даалгасугай.

5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв/хуучнаар/-ийн даргын 2003 оны 100 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

013

00000095

МОНГОЛ УЛСЫН ИРГЭНИЙ ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ,
ЦАГААЧЛАХ ЭРХИЙГ ТҮР ТҮДГЭЛЗҮҮЛЭХ БОЛОН ИРГЭНИЙ
БАРИМТ БИЧИГТ БҮРТГЭЛ ХӨТЛӨХӨД ХОРИГ ТАВИХ,
ЦУЦЛАХ БҮРТГЭЛ ХӨТЛӨХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын иргэний гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг түр түдгэлзүүлэх /цаашид "түдгэлзүүлэх" гэх/ бүртгэл хөтлөх, иргэний баримт бичигт бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хориг тавих /цаашид "хориг тавих" гэх/, түдгэлзүүлсэн болон хориг тавьсныг цуцлах /цаашид "цуцлах" гэх/-тай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Түдгэлзүүлэх болон хориг тавих, цуцлах үйл ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний бүртгэлийн тухай хууль, Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хууль, бусад хууль тогтоомж болон энэ журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Түдгэлзүүлэх болон хориг тавих үндэслэл, шалтгаан

2.1.Дараахь үндэслэлээр түдгэлзүүлэх болон хориг тавина:

2.1.1.энэ журмын 2.2.1-2.2.4-д заасан шалтгаанаар эрх бүхий байгууллагаас албан бичиг, хүсэлт ирүүлсэн;

2.1.2.энэ журмын 2.2.5-д заасан шалтгаанаар иргэний баримт бичигт бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хориг тавих талаар бүртгэлийн хяналтын улсын байцаагч шийдвэр гаргасан.

2.2.Дараахь шалтгаанаар түдгэлзүүлэх болон хориг тавина:

2.2.1.тухайн этгээд гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан;

2.2.2.эрүүгийн ял шийтгүүлсэн;

2.2.3.хуулиар тогтоосон төрийн нууцыг мэдэж байгаа болон түүнийг шууд хариуцаж байгаа албан тушаалтан цагаачлах хүсэлт гаргасан;

2.2.4.гадаадад зорчих, цагаачлах нь бусад хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хохироож байгаа тухай нөгөө этгээд буюу байгууллагын өргөдөл, гомдол байгаа бөгөөд эрх бүхий байгууллага түүнийг үндэслэлтэй гэж үзсэн;

2.2.5.хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн, хаяж үрэгдүүлсэн.

Гурав. Түдгэлзүүлэх болон хориг тавих хугацаа

3.1.Түдгэлзүүлэх болон хориг тавих хугацаа нь дараахь хугацаагаар тодорхойлогдоно:

3.1.1.энэ журмын 2.2.1-д заасан шалтгаанаар уг хэргийг шийдвэрлэх хүртэл;

3.1.2.энэ журмын 2.2.2-д заасан шалтгаанаар уг ялыг эдэлж дуусах буюу ялаас чөлөөлөх хүртэл;

3.1.3.энэ журмын 2.2.3-д заасан шалтгаанаар уг ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн өдрөөс хойш 3 жилийн дотор;

3.1.4.энэ журмын 2.2.4-д заасан шалтгаанаар уг асуудлыг шийдвэрлэх хүртэл;

3.1.5.энэ журмын 2.2.5-д заасан шалтгаанаар 2 жил хүртэл хугацаагаар болон тухайн бүртгэлийн зөрчлийг шийдвэрлэх хүртэл хугацаанд.

Дөрөв.Түдгэлзүүлсэн болон хориг тавьсныг цуцлах

4.1.Дараахь үндэслэлээр түдгэлзүүлсэн болон хориг тавьсныг цуцална:

4.1.1.энэ журмын 2.2.1-2.2.4-д заасан шалтгаанаар түдгэлзүүлэх эрх бүхий байгууллагаас түдгэлзүүлснийг цуцалсан албан бичиг, хүсэлт ирүүлсэн;

4.1.2.энэ журмын 2.2.5-д заасан шалтгаанаар хориг тавьсныг цуцалсан тухай бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн шийдвэр гарсан.

4.1.3.түдгэлзүүлэх болон хориг тавихад тогтоосон хугацаа өнгөрсөн.

Тав.Түдгэлзүүлсэн болон хориг тавьсан, цуцалсан тухай бүртгэл хөтлөх

5.1.Түдгэлзүүлсэн болон хориг тавьсан, цуцалсан тухай бүртгэлийг улсын хэмжээнд нэгтгэн хөтлөх чиг үүргийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн хяналтын газар хэрэгжүүлнэ.

5.2.Түдгэлзүүлсэн болон хориг тавьсан, цуцалсан бүртгэлийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Бүртгэлийн хяналтын газрын Хяналтын улсын ахлах байцаагч хөтөлнө.

5.3.Бүртгэл хөтлөх эрх бүхий этгээд нь түдгэлзүүлсэн болон хориг тавьсан тухай дараахь агуулга бүхий мэдээллийг улсын бүртгэлийн цахим санд хөтөлнө:

5.3.1.гадаадад зорчих эрх нь түдгэлзсэн болон хориг тавигдсан этгээдийн овог, нэр, регистрийн дугаар, иргэний баримт бичгийн болон гадаад паспортын дугаар;

5.3.2.түдгэлзүүлсэн болон хориг тавигдсан шалтгаан;

5.3.3.түдгэлзүүлсэн эрх бүхий байгууллагын албан бичгийн дугаар болон хориг тавьсан бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийн дугаар, огноо, байгууллага, албан тушаалтны нэр, бүртгэл хөтөлсөн этгээдийн нэр, хориг тавьсан огноо.

5.4.Бүртгэл хөтлөх эрх бүхий этгээд нь түдгэлзүүлсэн болон хориг тавьсныг цуцалсан тухай дараахь агуулга бүхий мэдээллийг улсын бүртгэлийн цахим санд хөтөлнө:

5.4.1.түдгэлзүүлснийг цуцалсан эрх бүхий байгууллагын албан бичиг болон хориг цуцалсан бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийн дугаар, огноо;

5.4.2.түдгэлзүүлсэн болон хориг тавьсныг цуцалсан байгууллага, албан тушаалтны нэр, бүртгэл хөтөлсөн этгээдийн нэр, цуцалсан огноо.

5.5.энэ журмын 4.1.3-д заасан журмыг улсын бүртгэлийн цахим сангийн програм хангамжаар зохицуулж болно.

5.6.Бүртгэл хөтлөх эрх бүхий этгээд нь түдгэлзүүлсэн, хориг тавьсан, цуцалсан талаарх бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн шийдвэр болон эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн албан бичгийн бүртгэлийн дэвтрийг хөтөлнө.

5.7.Түдгэлзүүлсэн, хориг тавьсан, цуцалсан бүртгэлийн дэвтрийн загвар болон хориг тавих, цуцлах тухай бүртгэлийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийн маягтын загварыг Бүртгэлийн хяналтын Ерөнхий байцаагч батална.

Зургаа.Бусад зүйл.

6.1.Энэ журмын 2.1.1-д заасан үндэслэлээр эрх бүхий байгууллагаас ирүүлсэн албан бичиг, хүсэлтийг шийдвэрлэх үйл ажиллагаанд “Улсын бүртгэлийн ерөнхий газрын баримт бичгийн эргэлтийг зохион байгуулах журам”-ыг баримтална.

6.2.Монгол Улсын иргэний гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах эрхийг энэхүү журамд зааснаас бусад үндэслэл, шалтгаанаар түдгэлзүүлэх, иргэний баримт бичигт бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд хориг тавихыг хориглоно.

Долоо.Хүлээлгэх хариуцлага

7.1.Энэхүү журмыг зөрчсөн буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

--- о О о ---